

ӨГҮҮЛЭЛ

Энэтхэг-Номхон далайн бүс дэх АНУ-ын гадаад бодлого ба Монгол Улс, АНУ-ын стратегийн түншлэл

*Дашнямын Золбоо**

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, доктор Ph.D

Цахим хаяг: zolbood@mas.ac.mn

Лүгүүшаравын Бямбаханд

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, магистр

Цахим хаяг: byambakhand_1@mas.ac.mn

Хураангуй: Монгол Улсын аюулгүй байдалд эерэг, сөрөг нөлөө бүхий байдал үүсэх нь хоёр хөри болон АНУ-тай харилцаагаа хэрхэн төлөвшүүлэх, тэдгээрийн ашиг сонирхлын шүтэлцээнд хэрхэн оролцохоос хамаарна. Иймээс Америкийн гадаад бодлого, харилцаа холбоог судлах нь түүний Азид явуулж буй бодлого, түүний дотор Монголтой харилцаж буй ашиг сонирхлын уялдааг судлах, улмаар Монгол Улсын АНУ-тай харилцах бодлогыг тодорхойлоход чухал. Нөгөө талаар, Монгол Улстай харилцах нь АНУ-ын Ази, Номхон далайн бүс нутагт чиглэсэн бодлогын нэг хэсэг байсаар ирсэн. Ерөнхийлөгч Д.Трампын засаг захиргаа дээр дурдсан бүс нутгийн нэршил, ойлголтыг өөрчлөн энэ бүс нутагт чиглэсэн бодлогоо Энэтхэг-Номхон далайн стратеги хэмээн тодорхойлох болов. 1987 онд дипломат харилцаа тогтоон, гурван жилийн өмнө дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг өргөн хүрээнд тэмдэглэсэн Монгол-АНУ-ын харилцаа 2019 онд шат ахин “Стратегийн түншлэл” болон хэлбэржлээ. Энэхүү өгүүллийн эхний хэсэгт АНУ-ын дэвшүүлсэн Энэтхэг-Номхон далайн стратеги гэгч юу болох, энэхүү стратегийн хүрээнд Монгол-АНУ харилцааны онцлог байдлын талаар судлаачийн байр сууриа илэрхийлэв.

Түлхүүр үгс: АНУ, Энэтхэг-Номхон далай, Монгол Улс, гуравдагч хөршийн бодлого, стратегийн түншлэл

1. Ази-Номхон далайгаас Энэтхэг-Номхон далай руу шилжих стратегийн шилжилт

Дэлхийн II дайны дараа буюу XX зууны сүүлийн хагасын АНУ-ын гадаад бодлогод “Asia First” буюу гадаад бодлогын чиглэлд Ази тивийн эзлэх байр суурь эн тэргүүнд тавигдсаар ирсэн хэмээн гадаад бодлого судлаачид дүгнэдэг. 1980-аад оны сүүлээс Ази, Номхон далай гэх нэр томъёо түгээмэл хэрэглэгдэх болжээ. Ази, Номхон далай бол Номхон далай хийгээд Ази тивийн Номхон далайн эрэг орчмын газар нутаг юм. Ази, Номхон далай гэх ойлголтыг тус бүс нутгийн орнууд оршин буй бүс нутгаа тодорхойлох зорилгоор хэрэглэх болсон. Тус бүс нутаг нь Зүүн Хойд Ази, Зүүн Өмнөд Ази, Далайн орнууд (Баруун өмнөд Номхон далай) гэх гурван дэд бүс нутгаас бүрдэнэ. Хэдийгээр нэр томъёоны хувьд геополитикийн үүднээс Энэтхэг улс нь энэ бүс нутагт хамаарч байгаа мэт боловч тус улсыг гадна орхисон хэмээн Энэтхэгийн судлаачид үздэг.¹

АНУ-ын Ерөнхийлөгч Б.Обамагийн засаг захиргаа Ази, Номхон далайн бүс нутаг дахь АНУ-ын оролцоо, нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор дахин тэнцвэржүүлэх бодлого хэрэгжүүлэхээ 2011 онд зарлаж байв. Тодруулбал, 2011 оны 11 сард Австралийн парламентад хэлсэн үгэндээ Б.Обама “АНУ нь Ази, Номхон далайн бүс нутаг, түүний ирээдүйг тодорхойлоход илүү бодитой, урт хугацаанд үргэлжлэх

үүрэг гүйцэтгэнэ” гэдгийг онцлон тэмдэглэжээ. Энэ нь Вашингтон 2001 оны 9 сарын 11-нээс хойш улс төр, батлан хамгаалах бодлогынхоо цөмийг Ойрх Дорнод руу шилжүүлсэн байсныг өөрчилсөн алхам болов. Ийнхүү “стратегийн хүндийн төв” өөрчлөгдсөнөөр Номхон далай, Атлантын далайд 50:50 харьцаатай байрласан тэнгисийн цэргийн хүчээ АНУ 2020 он гэхэд 60:40 харьцаатай болгон өөрчлөн байрлуулахаа мэдэгдсэн. Хэдийгээр тухайн үед Вашингтон энэ бодлогыг Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн ач холбогдол өссөнтэй холбон тайлбарлаж байсан боловч Хятадын өсөн нэмэгдэж буй нөлөөг хязгаарлах зорилготой байсан нь нууц биш.

Харин Бүгд найрамдах намын нэр дэвшигч Д.Трамп АНУ-ын ерөнхийлөгч болсноор тус улсын Ази, Номхон далайн бүс нутагт чиглэсэн бодлогод өөрчлөлт гарсан. Ерөнхийлөгч Д.Трамп 2017 оны 11 сард Азийн орнуудад хийсэн айлчлалынхаа хүрээнд Вьетнамын Да нанг хотод АПЕК-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр Энэтхэг-Номхон далайн стратегийг албан ёсоор танилцуулсан. Тэрээр хуулийн засаглал, хувь хүний эрх, эрх чөлөө, далай, тэнгист чөлөөтэй зорчих зэргийн ач холбогдлыг онцлов. Эдгээр нь Энэтхэг-Номхон далайн стратегийн цөм болсон үнэт зүйлс бөгөөд АНУ-ын зүгээс энэ бүс нутаг дахь холбоотон,

1 IDSA “What does the term “Indo-Pacific” signifies, as distinct from Asia-Pacific? ”<https://idsa.in/askanexpert/termIndoPacifcsignifies> (accessed April 1, 2020)

түншүүдтэйгээ нийтлэг үнэт зүйлд тулгуурласан олон улсын дэг журмыг бэхжүүлэхийн төлөө ажиллана хэмээн мэдэгдээд байгаа билээ.

“Энэтхэг-Номхон далай”-г ихээхэн ярвигтай ойлголт гэдэг. Зарим эх сурвалжид Энэтхэгийн далай, баруун болон төв Номхон далай, түүний дотор Өмнөд Хятадын тэнгисийг багтаасан геополитикийн бүс нутаг² хэмээн тодорхойлсныг үзэж болно. Харин Австралийн үндэсний аюулгүй байдлын стратегич Рори Медкалф “Энэтхэгийн далай, Баруун Номхон далайн хоорондын гүнзгийрч буй харилцаа холбоог Энэтхэг-Номхон далай гэх нэр томъёо илэрхийлнэ” хэмээн үзсэн. Мөн Энэтхэгийн далайд Хятадын өсөн нэмэгдэж буй нөлөө (жишээлбэл, БНХАУ нь Жибутид цэргийн бааз байгуулж, Шри-ланк, Мальдивтай харилцаагаа гүнзгийрүүлж буй) нь энэ далай, тэнгисийн орон зайд гаргасан стратегийн бодит байдлыг тодорхойлж байна.³ Япон, Энэтхэг улсын тухайд, Номхон далай, Энэтхэгийн далайн дагуу орших Ази, Африк гэсэн хоёр тивийг хамруулан ойлгож байна. АНУ тус бүс нутагт хуучин Ази, Номхон далайн бүс нутагт хамрагдаж байсан орнууд дээр нэмээд Энэтхэгийг

хамруулан ойлгодог.⁴ Харин энэхүү өгүүлэлд судлаачид АНУ-ын байр суурийн талаас үзэж байгаа тул Энэтхэг-Номхон далай гэх ойлголтыг дээрхтэй адил Ази, Номхон далайн бүс нутагт багтдаг орнууд болон Энэтхэг улсыг хамруулан авч үзлээ. Товчхондоо АНУ-ын энэ бүс нутагт хэрэгжүүлж буй гадаад бодлогыг “Энэтхэг-Номхон далайн стратеги” хэмээх ойлголтод багтааж ойлгож болно.

АНУ-ын Төрийн Департаментын Дэд туслах нарийн бичгийн дарга Алекс Н.Воны үзснээр, “Энэтхэг-Номхон далайн стратеги нь ардчиллын үнэт зүйлсийн хүрээнд нийтээр харилцан тохирсон олон улсын эрх зүйн хэм хэмжээ, дүрэм журмыг баримтлан бүс нутгийн орнууд хэлхээ холбоогоо бэхжүүлэх явдлыг хэлнэ. Иймээс нийтлэг ардчилсан үнэт зүйлтэй АНУ, Австрали, Япон, Энэтхэг зэрэг орнуудад хамтран ажиллах өргөн боломжийг нээж байна. Уг стратегийн “чөлөөт”, “нээлттэй” гэх зарчим нь Трампын засаг захиргааны хувьд хэрхэн илэрхийлэгдэж байгааг дараах байдлаар тодорхойлсон байдаг”.⁵

- 2 The Economic Times “US, India, Japan, Australia for ASEAN-led mechanism to promote rules-based order in Indo-Pacific”, Jun 1, 2019, <https://economictimes.indiatimes.com/news/defence/us-india-japan-australia-for-asean-led-mechanism-to-promote-rules-based-order-in-indo-pacific/articleshow/69610387.cms?from=mdr> (accessed April 1, 2020)
- 3 Alyssa Ayres “The U.S. Indo-Pacific Strategy Needs More Indian Ocean” Council on Foreign Relations, Jan 22, 2019, <https://www.cfr.org/expert-brief/us-indo-pacific-strategy-needs-more-indian-ocean> (accessed April 1, 2020)
- 4 Kai He and Li Mingjiang “Four reasons why the Indo-Pacific matters in 2020” <https://blog.oup.com/2020/02/four-reasons-why-the-indo-pacific-matters-in-2020/> (accessed April 1, 2020)
- 5 Le Hong Hiep “America’s Free and Open Indo-Pacific Strategy: A Vietnamese Perspective” ISEAS 2018 No.43 (Aug 7, 2018)

Нэр томъёо	Тодорхойлолт
Чөлөөт	Хүч хэрэглэхээс ангид (чөлөөтэй байх)
	Сайн засаглал (хүний суурь эрх, ил тод, авлигагүй байдал)
Нээлттэй	Нээлттэй далай тэнгис, агаарын зам
	Нээлттэй логистик (дэд бүтэц)
	Нээлттэй хөрөнгө оруулалт
	Нээлттэй худалдаа (чөлөөт, шударга, харилцан ашигтай худалдаа)

Энэтхэг-Номхон далайн стратеги нь нийтээр харилцан тохирсон олон улсын хэм хэмжээ, дүрэм журмын хүрээнд бүс нутгийн орнууд хэлхээ холбоо бий болгох гол зарчмаа болгож байгаа хэмээн тайлбарлаж байна. Энэ нь нийтлэг ардчилсан үнэт зүйлтэй АНУ, Австрали, Энэтхэг, Япон зэрэг орнууд хамтран ажиллах бололцоо нээж байна хэмээн дүгнэсэн.

Түүнчлэн, Энэтхэг-Номхон далайн бүс нутаг нь АНУ-ын стратегийн тэргүүлэх чиглэл болсон. 2017 оны 12 сарын 18-ны өдөр танилцуулсан АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегид Энэтхэг-Номхон далай хэмээх ойлголтыг анх удаа хэрэглэсэн байна.⁶ Ингэхдээ тус бүс нутгийг Ойрх Дорнод, Европоос өмнө хамгийн түрүүнд дурдсан нь анхаарал татаж байна.⁷ Түүнчлэн, энэ стратегид “Хятад, Орос зэрэг ревизионист их гүрнүүд технологи, суртал ухуулга, хүч хэрэглэн Америкийн ашиг сонирхол, үнэт зүйлийн эсрэг дэлхий ертөнцийг бий болгохыг оролдож байна” хэмээн илэрхий дурдсан.

Үүгээр дээрх хоёр улсыг АНУ-ын өрсөлдөгчид болохыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд уг стратегийн үзэл санааг тодорхой харуулж байна хэмээн үзэж болох юм.

Энэхүү стратегийг өмнөх засаг захиргааны АНУ-ын дахин тэнцвэржүүлэх бодлогын шууд үргэлжлэл хэмээн үзэж болно. Дээр дурдсан стратегиар дамжуулан Энэтхэгт ач холбогдол өгч Хятадын өсөн нэмэгдэж буй нөлөөг хязгаарлах зорилго агуулж байна. Тиймээс энэ бодлогыг өмнөх ерөнхийлөгчийн хэрэгжүүлж байсан Хятадыг тогтоон барих зорилготой дахин тэнцвэржүүлэх бодлогын үргэлжлэл хэмээн дүгнэж болно. Гэхдээ энэхүү стратеги дахин тэнцвэржүүлэх бодлогоос ялгаатай нь хэлбэрийн хувьд “Энэтхэг-Номхон далай” хэмээх нэрийг ашиглах болсон нь бүс нутаг дахь Энэтхэг зэрэг ардчилсан тогтолцоотой түншүүдэд ач холбогдол өгсөн хэмээн тайлбарлаж болох юм.

“Энэтхэг-Номхон далайн стратеги”-ийн хүрээнд Ерөнхийлөгч

6 Alyssa Ayres “The U.S. Indo-Pacific Strategy Needs More Indian Ocean” *Council on Foreign Relations*, Jan 22, 2019, <https://www.cfr.org/expert-brief/us-indo-pacific-strategy-needs-more-indian-ocean> (accessed April 1, 2020)

7 The United States “*National Security Strategy of the United States of America*” (2017)

Д.Трамп Хятадын талаар хатуу байр суурь баримталж болзошгүйг АНУ-БНХАУ-ын худалдааны дайн харуулж байна. Юанийн ханшийг зориудаар доогуур тогтоох замаар худалдааны тэнцлийг өөрт ашигтай байлгадаг, Америкийн оюуны өмч, технологийг “хулгайлах” замаар шударга бус өрсөлдөж, тус улсын эдийн засагт асар их хэмжээний хохирол учруулдаг хэмээн АНУ-ын тал БНХАУ-ыг буруутгасаар байна. Энэ шалтгаанаар Ерөнхийлөгч Д.Трамп БНХАУ-д худалдааны татвар ноогдуулахаар шийдвэрлэсэн билээ. Улмаар энэ нь “худалдааны дайн” болон өргөжиж, Вашингтон, Бээжин харилцан ихээхэн хэмжээний худалдааны татвар ноогдуулахаар зарласан билээ.

Товчхондоо, Энэтхэг-Номхон далайн стратеги гэдгийг (1) бүх улс үндэстний бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг хүндэтгэх; (2) маргааныг энхийн аргаар шийдвэрлэх; (3) нээлттэй хөрөнгө оруулалт, ил тод гэрээ хэлэлцээр, хэлхээ холбоонд тулгуурласан чөлөөт, шударга, харилцан ашигтай худалдаа; (4) далай тэнгис, агаарын орон зайд чөлөөтэй зорчих зэрэг олон улсын эрх зүйг баримтлахын төлөө ажиллах

хэмээн зарласан билээ.⁸ Энэ нь цаагуураа Хятадыг сөргүүлсэн стратеги болохыг илтгэж байна. АНУ тэргүүтэй Өрнийн улсууд Өмнөд Хятадын тэнгис зэрэг маргаантай газар нутгуудад олон улсын эрх зүйн зарчмууд, түүний дотор соёрхон баталсан атлаа “Далайн эрх зүйн конвенц”-ийг хэрэгжүүлэхэд хойрго хандаж, газар нутгийн маргааныг хоёр талын хүрээнд шийдвэрлэхийг зорьдог хэмээн Хятадыг буруутгадаг. Мөн Парсель болон Спрателийн арлуудад 27 цэргийн байгууламж байгуулан, Вүүдий аралд байлдааны нисэх онгоцууд, пуужингууд болон радарын систем байгуулан цэрэгжүүлж, маргаантай арлуудад бусад улс чөлөөтэй зорчих боломжийг хязгаарлаж байна хэмээн Бээжинг буруутгасаар байгаа.

АНУ-ын Батлан хамгаалахын сайд асан Жэймс Маттис 2018 оны 6 дугаар сард Шангри-лагийн яриа хэлэлцээнд оролцож, үг хэлэхдээ Энэтхэг-Номхон далайн стратегийн үндсэн чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлсон.⁹ (Диаграмм 1)

Түүнчлэн, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майк Помпео 2018 оны 7 сард Энэтхэг-Номхон далайн

Диаграмм 1

Энэтхэг-Номхон далайн стратегийн үндсэн чиглэлүүд			
Далай, тэнгисийн орон зайд анхаарлаа нэмэгдүүлэх	Холбоотон, түншүүдтэйгээ тогтоосон хэлхээ холбоо (харилцан ажиллах чадвар)-гоо бэхжүүлэх	Эрх зүйт ёс, иргэний нийгэм, ил тод засаглалыг бэхжүүлэх	Хувийн салбар тэргүүлсэн эдийн засгийн хөгжлийг бий болгох

8 The United State Department , “A free and open indo-pacific: Advancing a Shared Vision” (2019)

9 Secretary Mattis, “Shangri-la Dialogue” (June 2, 2018) <https://dod.defense.gov/News/Transcripts/Transcript-View/Article/1538599/remarks-by-secretary-mattis-at-plenary-session-of-the-2018-shangri-la-dialogue/>(accessed April 1, 2020)

эдийн засгийн форумд оролцох үеэрээ уг стратегийг эдийн засгийн чиглэлд “дигитал эдийн засаг”, “эрчим хүч”, “дэд бүтэц” гэсэн дараах 3 салбарт хэрэгжинэ хэмээн тодорхойлжээ.

М.Помпеогийн хэлсэн үгнээс үзвэл Энэтхэг-Номхон далайн стратеги нь эдийн засгийн чиглэлд хөрөнгө оруулалт, хөгжлийг чухалчлан үзэх төлөвтэй байна. Ингэхдээ Америкийн дэлхийн бусад улсаас давуу талтай байдаг дигитал эдийн засагт төвлөрөх нь хөгжиж буй орнуудын сонирхлыг татах магадлалтай. Нөгөө талаар, эрчим хүч, дэд бүтцийн салбарын хөгжилд анхаарснаар тус бүс нутгийн орнуудын хэрэгцээ шаардлагыг мэдэрч чадсан хэрэг болж байна. Учир нь Азийн хөгжлийн банкны тооцоогоор, Азийн хөгжүүлэхэд 2030 он хүртэл жил бүр 1.7 их наяд ам.долларыг дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт болгох шаардлагатай. БНХАУ ч энэ хэрэгцээ шаардлагыг тооцоолон “Нэг Бүс Нэг Зам” санаачилгыг 2013 онд зарлан, хэрэгжүүлж буйг энд сануулъя.

Энэтхэг-Номхон далайн стратегийг хэрэгжүүлэх санхүүгийн механизмууд бүрэлдэн бий болж байна. АНУ-ын Конгрессын 2018 оны 10 дугаар сард баталсан Хөгжилд хөтлөх зорилгоор хөрөнгө оруулалтыг илүү сайн ашиглах тухай (Better Utilization of Investments Leading to Development) хуулийн дагуу Хилийн чанад дахь хөрөнгө оруулалтын корпораци болон бусад байгууллагыг нэгтгэн 60 тэрбум ам.долларын төсөвтэй АНУ-ын Олон

улсын хөгжлийн санхүүгийн корпорац (The United States International Development Finance Corporation)-ийг байгуулахаар болсон бөгөөд тус байгууллага нь гадаад орнуудын хөгжлийг дэмжих зорилгоор хөрөнгө оруулах, техникийн туслалцаа үзүүлэх, зээлийн баталгаа гарган ажиллах юм байна.

Түүнчлэн, Ерөнхийлөгч Д.Трамп АНУ-ын Сенатын сарын өмнө батлаад байсан Азийн баталгааны санаачилгын хууль (Asia Reassurance Initiative Act)-д 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гарын үсэг зурсан билээ. Цагаан ордоны мэдэгдэлд дурдснаар энэхүү хууль нь Энэтхэг-Номхон далайн бүс нутагт АНУ-ын аюулгүй байдал, эдийн засгийн ашиг сонирхол, үнэт зүйлсийг нэмэгдүүлэх АНУ-ын олон талт стратегийг бий болгоход¹⁰ чиглэх ажээ. Тодруулбал, Энэтхэг-Номхон далайн бүс нутагт урт хугацааны стратегийн алсын хараа болон АНУ-ын иж бүрэн, олон талт зарчимд суурилсан бодлогыг хөгжүүлэх болон бусад зорилгоор Зүүн болон Зүүн өмнөд Азид АНУ-ын хэрэгжүүлэх олон төрлийн хөтөлбөрүүдэд 1.5 тэрбум ам.долларыг зарцуулах эрхийг энэ хууль олгож байгаа юм.¹¹

АНУ-ын засгийн газрын санаачилга болох Asia Edge нь Энэтхэг-Номхон далайн бүс нутагт тогтвортой, аюулгүй эрчим хүчний зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн бөгөөд тус бүс нутагт эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх, эрчим хүчний

10 The White House “Bill Announcement” (Dec 31, 2018) <https://www.whitehouse.gov/briefings-statements/bill-announcement-12/> (accessed April 20, 2020)

11 Ankit Panda, “Trump Signs Asia Reassurance Initiative Act into Law” (Jan 3, 2019) <https://thediplomat.com/2019/01/trump-signs-asia-reassurance-initiative-act-into-law/>(accessed April 20, 2020)

төрөлжилт, худалдааг нэмэгдүүлэх, эрчим хүчинд холбогдох бололцоог нэмэгдүүлэх зорилготой. 2018 оны 7 дугаар сард гараагаа эхэлсэн энэ санаачилгад АНУ-ын засгийн газар, хувийн хэвшил, олон улсын санхүүгийн байгууллагуудын мэдлэг ур чадвар, нөөцийг татан оролцуулна.¹² Тус санаачилгыг Хятадын “Нэг Бүс Нэг Зам” санаачилгын альтернатив хэмээн үзэж байна.

“Нэг Бүс Нэг Зам” санаачилга хүрээгээ тэлэхийн хэрээр улс орнууд БНХАУ-ыг алгаа дэлгэн угтах нь байгаа ч, эсэргүүцэн дургүйцэх хандлага ч гарч байна. Хөрөнгө оруулалт ил тод бус, бага хүүтэй их хэмжээтэй зээл нь буурай эдийн засагтай орнуудад дарамт болж байна гэж үзэх нь ч бий. Тухайлбал, Мьянмар улс хүрээлэн буй орчны асуудал, Хятадын нөлөө давамгайлсан гэх шалтгаанаар БНХАУ-ын хөрөнгө оруулалттай хамгийн том төсөл болох Maitson-ий далангийн барилгын ажлыг зогсоосон бол Шри-ланка улс 2017 оны 12 сард БНХАУ-аас авсан зээлээ эргүүлэн төлж чадахгүй болсон тул тус боомтыг эргэн тойрны 1500 га газрын хамт Хятад улсад 99 жилийн хугацаатай түрээслүүлэхээс аргагүйд хүрсэн. Хятадын “Нэг

Бүс Нэг Зам” санаачилгыг “өрийн хавхны дипломат ажиллагаа” хэмээн шүүмжлэгчид нэрлэх болсны нэг шалтгаан нь энэхүү боомт юм. Зээлийн хүүгээ төлөх чадваргүй жижиг эдийн засагтай орнуудын үр өгөөжгүй дэд бүтцийн төслүүдэд “бага хүү”-тэй гэх нэрийн дор зээл олгон өрийн дарамтад оруулдаг энэ тогтолцоог “өрийн хавх”-ны бодлого хэмээдэг. Ийнхүү өрийн хавханд орсон орнууд Хятадад үндэсний, стратегийн ашиг сонирхол бүхий газар нутаг, өмч хөрөнгөө шилжүүлэхээс аргагүйд хүрч байна.

“Нэг Бүс Нэг Зам” санаачилгаас ялгаатай нь, Asia Edge санаачилга “өрийн дипломат ажиллагаа”-нд тулгуурлах бус харин түнш орнуудын эрчим хүчний төлөвлөгөөнд суурилна гэдгийг АНУ-ын Эрчим хүчний нөөцийн товчооны Туслах нарийн бичгийн дарга Францис Фаннон хэмээн мэдэгдсэн юм. Мөн тэрээр “энэ санаачилгад ямар нэгэн албадагын зүйл огтхон ч байхгүй. Бид өөртөө засан тогтнох зарчимд тулгуурлан, тодорхой эрчим хүчний бодлого хэрэгжүүлж буй улсуудад бүрэн ил тод, уян хатан тогтолцоог санал болгоно” хэмээсэн. Тус санаачилгын стратегийн зорилтуудыг (Диаграмм 2) байдлаар тодорхойлсон байна.

Диаграмм 2

Asia-Edge санаачилгын стратегийн зорилтууд			
Холбоотон, түншүүдийнхээ эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх	Нээлттэй, үр ашигтай, зарчимд суурилсан, ил тод эрчим хүчний зах зээлийг бий болгох	Чөлөөт, шударга, харилцан ашигтай худалдааны харилцааг сайжруулах	Хүртээмжтэй, найдвартай эрчим хүч авах бололцоог нэмэгдүүлэх

12 The USAID “Enhancing Development and Growth through Energy” (Feb 6, 2020)<https://www.usaid.gov/energy/asia-edge>(accessed April 5, 2020)

Мөн АНУ нь 100 сая ам.долларын санхүүжилттэй Номхон далайн амлалт (Pacific Pledge) шинэ санаачилгыг 2019 оны 9 сард зарласан. Энэ нь АНУ-ын агентлагууд бүс нутгийн хүн ардад зориулан хөгжил дэвшил бүхий ирээдүйг бий болгохын тулд төсөл, тусламж, үйл ажиллагаанд жил бүр зарцуулдаг 350 сая ам.долларын хөрөнгө оруулалтад нэмэлт болох юм. Энэхүү Номхон далайн амлалт (Pacific Pledge) санаачилгын хэсэг болгон, АНУ-ын Хөгжлийн агентлаг (USAID) нь шинэ хөтөлбөрүүдэд 62 сая ам.долларыг зарцуулахаар төлөвлөж байгаа нь тус улсын хөгжлийн тусламжийн дүнг хоёр дахин нэмэгдүүлэх юм.¹³

2019 оны 11 сард Тайланд улсад болсон Ази-Номхон далайн форумд оролцохдоо АНУ, Япон, Австрали улс “Хөх цэгийн сүлжээ” (Blue Dot Network)-г байгуулах болсноо зарласан. Эдгээр холбоотон гурван улс дэлхий даяар ил тод, тогтвортой байдлын өндөр стандартад нийцэх, хөгжлийн нөлөө үзүүлэх төслүүдэд баталгаа гаргахаар төлөвлөж байна. Хөх цэгийн сүлжээнд нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцогчид хамрагдаж байгаа бөгөөд нээлтэй, багтаамжтай, ил тод, эдийн засгийн хувьд боломжтой, санхүү, байгаль орчин, нийгмийн хувьд тогтвортой, олон улсын стандарт, хууль

тогтоомжид нийцсэн дэд бүтцийн чанартай хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготой¹⁴ ажээ. Хэдэн арван их наяд ам.долларын урт хугацааны хөрөнгө оруулалтыг зохицуулах үүрэгтэй ажилладаг Америкийн тэтгэврийн сангууд, даатгалын компаниуд ирэх 20 жилийн хугацаанд дэлхийн даяар шаардлагатай 94 их наяд ам.долларын өртөг бүхий төслүүдэд хөрөнгө оруулах юм. Мөн Энэтхэгийн Ерөнхий сайд Н.Модигийн 2020 оны 2 сард АНУ-д хийсэн айлчлалын үеэр АНУ-ын зүгээс дөрвөн талт механизмын хүрээнд “Хөх цэгийн сүлжээ”-нд Энэтхэг улсыг оролцохыг урьсан байна. Шинэ Дели энэ санаачилгад оролцох сонирхолтойгоо айлчлалынхаа үеэр гаргасан “БНЭУ-АНУ дэлхийн хэмжээний иж бүрэн стратегийн түншлэлийн төлөө алсын хараа, зарчмууд” хэмээх хамтарсан мэдэгдэлд дурджээ.¹⁵

Товчлон дүгнэвэл, Вашингтоны зүгээс тус сүлжээг Хятадын “Нэг Бүс Нэг Зам” санаачилгыг сөрөх зорилгогүй хэмээн мэтгэж байгаа боловч ажиглагчид үүнийг бүс нутагт Хятадын өсөн нэмэгдэж буй нөлөөг хязгаарлах зорилготой хэмээн¹⁶ тайлбарлаж байна. Учир нь энэ бүс нутагт БНХАУ нь “Нэг Бүс Нэг Зам” санаачилгын хүрээнд дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, тэдгээрийг санхүүжүүлэх

13 The United State Department , “A free and open Indo-Pacific: Advancing a Shared Vision” (2019)

14 The United State Department, “Blue dot network” (2020) <https://www.state.gov/blue-dot-network/> (accessed April 10, 2020)

15 Nayanima Basu “Blue Dot Network-Us answer to China’s Belt & Road Initiative that India’s ‘interested’ in”, *The Print*, March 10, 2020 <https://theprint.in/theprint-essential/blue-dot-network-us-answer-to-chinas-belt-road-initiative-that-indias-interested-in/378457/> (accessed April 10, 2020)

16 Mercy A. Kuo “Blue Dot Network: The Belt and Road Alternative: Insights from Matthew P. Goodman”, *The Diplomat*, April 07, 2020 <https://thediplomat.com/2020/04/blue-dot-network-the-belt-and-road-alternative/> (accessed April 10, 2020)

“Торгоны зам сан”, “Азийн дэд бүтэц, хөгжлийн банк” зэрэг санхүүгийн механизмыг бий болгосныг сөргүүлэн Энэтхэг-Номхон далайн стратегийн чиглэлүүдийг тодорхойлноос үзвэл энэ бүс нутаг дахь Хятадын нөлөөг хумих гэсэн Америкийн геополитикийн ашиг сонирхлыг харуулж байна. Өргөн утгаараа, АНУ-ын Энэтхэг-Номхон далайн стратеги нь олон улсын харилцаанд Америкийн давамгайллыг хадгалах, шинээр

хүчирхэгжиж буй Хятадын тэлэлтийг хазаарлах, АНУ-ын санал болгодог “Вашингтоны зөвшилцөл”-ийг сөргүүлэн гарч ирсэн Хятадын либерал бус замнал болох “Бээжингийн зөвшилцөл”-ийг тогтоон барих гэсэн геополитикийн далд сонирхлын илэрхийлэл болж байгаа бөгөөд энэ нь их гүрнүүдийн хооронд зөрчилдөөнийг улам ихээр хурцдуулах үйлдэл болох магадлалтай байна.

2. Стратегийн түншлэлд дэвшсэн Монгол Улс - АНУ-ын харилцаа

АНУ-ын өнөөгийн Ерөнхийлөгч Д.Трампын засаг захиргаа өөрийн гадаад бодлогын хүрээнд Монгол Улсыг “Энэтхэг-Номхон далайн стратеги”-д хамруулан харилцаж байна. Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн тухай Монгол, АНУ-ын хамтарсан тунхаглалд Монгол Улсыг Энэтхэг-Номхон далайн бүс нутаг дахь чухал түнш хэмээн тодорхойлсон байдаг.¹⁷

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Бушийн урилгаар АНУ-д 2004 оны 7 сард айлчлах үеэр “Монгол Улс, АНУ-ын хамтарсан мэдэгдэл” гарч, хоёр талын харилцааг “Стратегийн нийтлэг ашиг сонирхолд тулгуурласан иж бүрэн түншлэл”-ийн хэмжээнд хөгжүүлэхээр тохиролцсон. Түүнээс 14 жилийн дараа Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн АНУ-д 2018 оны 9 сард хийсэн албан ёсны айлчлалын

үеэр хоёр тал харилцааныхаа түвшинг ахиулан “Өргөтгөсөн иж бүрэн түншлэл”-ийг хөгжүүлэхээр тохиролцсон. Жил хүрэхгүй хугацааны дараа буюу 2019 оны 7 сард Ерөнхийлөгч Х.Баттулгын АНУ-д хийсэн айлчлалын үеэр манай хоёр улс “Стратегийн түншлэл” байгуулахаар шийдвэрлэсэн.¹⁸ Ойрхон хугацаанд ийнхүү хоёр талын харилцааны түвшинг ахиулах болсныг АНУ нь бүс нутагт чиглсэн гадаад бодлогоо “Энэтхэг-Номхон далайн стратеги” хэмээн тодорхойлон хэрэгжүүлэх болсноор Монгол Улсад тавих анхаарал нэмэгдсэн, нөгөө талаар Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын чухалчлан үзэж тууштай дэмжсээр ирсний бодит үр дүн хэмээн дүгнэж болохоор байна.

Энэтхэг-Номхон далайн стратегийн хүрээнд хоёр талын харилцааг цаашид өргөжүүлэх, ялангуяа өнгөрсөн 30

17 Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн тухай Монгол, АНУ-ын хамтарсан тунхаглал <http://www.mfa.gov.mn/?p=47816> (accessed April 10, 2020)

18 Монгол Улсын Ерөнхийлөгч. (2019, 8 1). *Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс дараах тунхаглалыг гаргаж байна.* <https://president.mn/10307/>

гаруй жилийн хугацаанд харьцангуй орхигдоод байсан эдийн засгийн харилцааг урагшлуулах боломж нээгдэнэ хэмээн судлаачид харж байна. Дэлхийд хамгийн том эдийн засаг бүхий АНУ-ын Монгол Улстай хийсэн худалдааны статистикийг харахад үнэхээр чамлалттай дүр зураг утгана. 2019 оны жилийн эцсийн байдлаар АНУ-аас импортлосон бараа бүтээгдэхүүний хэмжээ манай улсын нийт импортын 4.7 хувь эзэлж байгаа бол АНУ-д экспортлосон бараа бүтээгдэхүүн нийт экспортын 0.13 хувийг эзэлж байна.¹⁹ Газарзүйн алслагдмал байдал үүнд нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй. Гэвч худалдаа эдийн засгийн харилцааг өргөжүүлэх зохион байгуулалт, шийдлийн асуудал харилцааны бусад салбараасаа хоцрогдолтой байсаар байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Тиймээс хоёр талаас идэвх, санаачилгатай ажиллавал энэ сул талыг нөхөх боломж бий. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилгаар, АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын гишүүн Тед Йохо нарын 10 гишүүн “АНУ-Монгол Улсын гуравдагч хөршийн худалдааны хууль”-ийн төслийг 2018 оны 7 сарын 26-ны өдөр өргөн барьсан. Энэхүү хуулийн төсөл батлагдвал Монголын оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ-ын зах зээлд татваргүй экспортлох замаар Монгол-Америкийн хоорондох худалдааг нэмэгдүүлэх боломжтой

болно.²⁰ Манай улс дээр дурдсан бараа бүтээгдэхүүнийг америкийн зах зээлд татваргүй нийлүүлэх боломжтой болсон тохиолдолд энэ боломжийг Хятадын хөрөнгө оруулагчид илүү ашиглах магадлал бий гэдгийг анхаарах шаардлагатай. 1999-ээс 2005 онд АНУ-аас Монгол Улсад олгосон хөнгөлөлттэй нөхцлийг Монгол Улс бүрэн хэмжээнд ашиглаж чадалгүй, Хятад, Хонг-Конгийн хөрөнгө оруулагчид манай квотоор өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ экспортлох боломж олгосон сургамж бий. Тиймээс Монгол Улсаас АНУ-д татваргүй нийлүүлэх оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний гарал үүслийг нарийвчлан тодорхойлох механизм бий болгох, ингэхдээ Монгол Улсад үйлдвэрлэгдэж, манай ажиллах хүч ажиллах эсэхэд хяналт тавих нь нэн чухал юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.2.2-т “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална”²¹ хэмээн заасан байдаг. Монгол Улс дахь ГШХО-ын талаас

19 Монгол Улсын Гаалийн Ерөнхий газар (2020). *Гадаад худалдаа 2019 онд*. Улаанбаатар хот: Монгол Улсын Гаалийн Ерөнхий газар

20 Монгол Улсын Ерөнхийлөгч. (2019, 8 1). *Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс дараах тунхаглалыг гаргаж байна*. <https://president.mn/10307/>

21 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2011 он www.nsc.gov.mn/?q=ns-concept

илүү хувь нь зөвхөн БНХАУ, Канад гэх хоёр орноос²² хийгдсэн байна. Энэ байдал нь Монгол Улсыг эдгээр орнуудын эдийн засгийн мөчлөгөөс хэт хамааралтай болгож хөрөнгө оруулалтын урсгалын тогтворгүй байдлыг нэмэгдүүлж байна.²³ Гэтэл АНУ-аас хийсэн хөрөнгө оруулалт нь нийт ГШХО-ын 4-хөн хувийг эзэлж байгаа нь чамлалттай тоо юм.

АНУ-ын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар тус улсын эдийн засгийн бодит ашиг сонирхлыг Монгол Улсад бий болгох боломжтой. Нөгөө талаар, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дээр дурдсан “гуравны нэг”-ийн зарчим алдагдахаас сэргийлэхэд америкийн хөрөнгө оруулалт бодитой нөлөө үзүүлнэ. Монгол Улс, АНУ нь хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ингэхдээ Ил тод байдлын хэлэлцээрийг тууштай хэрэгжүүлэх, хоёр талын худалдаанд шинэ салбар, боломжийг нээх, дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор АНУ-ын Эксим банк, Хилийн чанад дахь хөрөнгө оруулалтын корпорацын оролцоог хөшүүрэг болгон ашиглах тухай хоёр тал тохиролцоод байгаа. Мөн “Хөх цэгийн сүлжээ”-нд оролцон АНУ-ын тэтгэврийн сангууд, даатгалын сангуудын хөрөнгө оруулалтыг Монгол Улсад татах боломж бий.

Ялангуяа Америкийн хөрөнгө

оруулалтыг дэд бүтцийн салбарт татах боломж бий. Шинээр байгуулсан АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүгийн корпорац нь гадаад орнуудын хөгжлийг дэмжих зорилгоор хөрөнгө оруулах, техникийн туслалцаа үзүүлэх, зээлийн баталгаа гаргах чиглэлд ажиллана. Уг байгууллагатай хамтран манай улсад дутагдалтай байгаа дэд бүтцийг байгуулах, сайжруулах, өргөжүүлэхэд хөрөнгө оруулалт татах боломжийг ашиглах нь зүйтэй.

Өмнө дурдсан АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майкл Р.Помпеон 2018 оны 7 сарын 30-ны өдрийн Энэтхэг-Номхон далайн бизнесийн форумд оролцоходоо “Чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далайг дэмжих нь” илтгэлдээ Монгол Улстай 350 сая ам.долларын компакт гэрээ хэрэгжүүлэх болсноо зарласан билээ.²⁴ Мөн Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн АНУ-д хийсэн айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хооронд 350 сая ам.долларын Хоёр дахь компакт гэрээ байгуулагдсан.²⁵ Компакт гэрээ хэрэгжих таван жилийн хугацаанд АНУ 350 сая ам.долларын тусламж үзүүлэх бөгөөд Монгол Улсын засгийн газар 111 сая ам.долларыг гаргаснаар нийт 461 сая ам.долларыг зарцуулна.²⁶ Уг тусламжийн хүрээнд хоёр талын харилцаа улам өргөжөөд зогсохгүй

22 Завиер Форнерис “Монгол Улс: хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлийн зураглал” https://www.mongolbank.mn/documents/press.../20191022_02e.pdf

23 Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлого, ХАА-н хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл “Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлийн зураглал” 2018 оны 6 дугаар сар

24 The United State Department, “A free and open indo-pacific: Advancing a Shared Vision” (2019)

25 Монгол Улсын Гадаад харилцааны яам. (2018 оны Sep 22). Мэдээ. Гаргасан 2018 оны Dec 1, Монгол Улсын Гадаад харилцааны яам: <http://www.mfa.gov.mn/?p=47869>

26 А.Санчир. (2018 оны 9 дүгээр сарын 19). *eagle.mn*. [eagle.mn: http://eagle.mn/r/50010](http://eagle.mn/r/50010)

байгальд ээлтэй дэд бүтцийг бий болгох замаар Улаанбаатар хотын усан хангамжийг сайжруулах, тэнд амьдарч байгаа иргэдийн амьдралын чанарыг

дээшлүүлэх зэргээр манай улсад хөгжлийн шинэ боломжийг бий болгох ажээ.

Дүгнэлт

Ерөнхийлөгч Д.Трампын засаг захиргаанаас хэрэгжүүлж буй гадаад бодлогын хүрээнд “Энэтхэг-Номхон далайн стратеги” АНУ-ын энэхүү бүс нутгийн улс орнуудтай тогтоосон харилцаагаа бэхжүүлэхэд багагүй түлхэц үзүүлж байна. Монгол Улстай харилцааныхаа түвшинг ахиулсан явдал нэг талаар АНУ-ын бодлоготой холбогдож байгаа боловч нөгөө талаар, энэ нь Монгол Улсын “Туравдагч хөрш”-ийн бодлого идэвхтэй хэрэгжиж байгаагийн илрэл юм. Өөрөөр хэлбэл, хоёр талын харилцаа шат ахиж, 2018 онд “Өргөтгөсөн иж бүрэн түншлэл”, 2019 онд “Стратегийн түншлэл”-ийн харилцаа болсон нь дан ганц америкийн талын санаачилгаас гадна манай улсын АНУ-тай бүхий л түвшинд, тэр дундаа эдийн засгийн салбарт өргөн хүрээнд хамтран ажиллах сонирхлын илэрхийлэл болж байна.

Манай хоёр улсын харилцааны түвшин ахиж байгааг Энэтхэг-Номхон далайн стратегитай холбон тайлбарлах оролдлого гарч болзошгүй юм. Монгол Улсын “Туравдагч хөрш”-ийн бодлого нь хөрш орнуудын ашиг сонирхлыг хүндэтгэх замаар дэлхийн бусад оронтой харилцан ашигтай, олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хамтран ажиллахад чиглэдэг. Харилцаа шат ахисан явдал нь хоёр орны ард түмнүүд өргөн хүрээнд харилцах нийтлэг ашиг сонирхолд нийцэж байгаа төдийгүй манай улсын эдийн засгийн хөгжлийг урагшлуулан, бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм. Товчхондоо АНУ-ын Энэтхэг-Номхон далайн стратегийн эдийн засгийн чиглэлээрх хамтын ажиллагаанд хоёр улс идэвхийлэн хамтран ажиллавал энэ нь Монгол Улсын ирээдүйн хөгжилд тустай, эдийн засгийн үр өгөөж авчрахаар байна.

Ашигласан материал

Англи хэлээр:

Alyssa Ayres More Prominence for India and the Indo-Pacific in the U.S. National Security Strategy. *CRF* (2017/Dec/17). <https://www.cfr.org/blog/more-prominence-india-and-indo-pacific-us-national-security-strategy>

Alyssa Ayres *The U.S. Indo-Pacific Strategy Needs More Indian Ocean*. [cfr.org](https://www.cfr.org/expert-brief/us-indo-pacific-strategy-needs-more-indian-ocean) (2019/1/22): <https://www.cfr.org/expert-brief/us-indo-pacific-strategy-needs-more-indian-ocean>

Basu, Nayanima “Blue Dot Network-Us answer to China’s Belt & Road Initiative that India’s ‘interested’ in”, *The Print*, March 10, 2020 <https://theprint.in/theprint-essential/blue-dot-network-us-answer-to-chinas-belt-road-initiative-that-indias-interested-in/378457/> (accessed April 10, 2020)

Brewster, D. “*A Free and Open Indo-Pacific and What Means for Australia*”. Lowy Institute Published 7 Mar 2018: <https://www.lowyinstitute.org/the-interpretor/free-and-open-indo-pacific-and-what-it-means-australia>

Chaturvedy, Rajeev Ranjan “Indo-Pacific: One Region, Many Visions?” RSIS Commentary No. 023 – 14 February 2019 <https://www.rsis.edu.sg/wp-content/2019/02/CO19023.pdf>

Economic Times *Trump signs legislation enhancing US leadership in Indo-Pacific region into law*. Jan 01 2019 <https://economictimes.indiatimes.com/news/defence/trump-signs-legislation-enhancing-us-leadership-in-indo-pacific-region-into-law/articleshow/67332642.cms?from=mdr>

Economic Times “US, India, Japan, Australia for ASEAN-led mechanism to promote rules-based order in Indo-Pacific”, Jun 1, 2019, <https://economictimes.indiatimes.com/news/defence/us-india-japan-australia-for-asean-led-mechanism-to-promote-rules-based-order-in-indo-pacific/articleshow/69610387.cms?from=mdr> (accessed April 1, 2020)

Foreignminister. (2019/01/09). *Address to the Raisina Dialogue*. Minister of Foreign Affairs : https://www.foreignminister.gov.au/speeches/Pages/2019/mp_sp_190109.aspx

Garver, John & Fei-Ling Wang. China’s Encirclement Struggle. *Asian Security* (Volume 6, 2010)., pp 238-261. <https://doi.org/10.1080/14799855.2010.507412>

Hiep, L. H. *America’s Free and Open Indo-Pacific Strategy: A Vietnamese Perspective*. Yusof Ishak Institute : https://www.iseas.edu.sg/images/pdf/ISEAS_Perspective_2018_43@50.pdf

IDSA “What does the term “Indo-Pacific” signifies, as distinct from Asia-Pacific?” <https://idsa.in/askanexpert/termIndoPacificsignifies> (accessed April 1, 2020)

India can play a more weighty role in Indo-Pacific region: U.S. (2018/04/03). www.hindu.com/news/

- international/india-can-play-a-more-weighty-role-in-indo-pacific-region-us/article23241165.ece
- Kai He and Li Mingjiang “Four reasons why the Indo-Pacific matters in 2020” <https://blog.oup.com/2020/02/four-reasons-why-the-indo-pacific-matters-in-2020/> (accessed April 1, 2020)
- Kuo, Mercy A. “Blue Dot Network: The Belt and Road Alternative: Insights from Matthew P. Goodman”, *The Diplomat*, April 07, 2020 <https://thediplomat.com/2020/04/blue-dot-network-the-belt-and-road-alternative/> (accessed April 10, 2020)
- Lian Degui “Four-way talks meant to contain China miss regional development demand” Source:Global Times Published: 2017/10/31: <http://www.globaltimes.cn/content/1072877.shtml>
- Liang Fang “Indo-Pacific strategy will likely share the same fate as rebalance to Asia-Pacific” Global Times Published: 2017/12/3 <http://www.globaltimes.cn/content/1078470.shtml>
- Remarks by Secretary Mattis at Plenary Session of the 2018 Shangri-La Dialogue. June 2, 2018 *Shangri-la Dialogue*. <https://www.defense.gov/Newsroom/Transcripts/Transcript/Article/1538599/remarks-by-secretary-mattis-at-plenary-session-of-the-2018-shangri-la-dialogue>
- Takenori, H. “Debate: The Indo-Pacific Region Needs a Strategy to Both Hedge, and Engage, China” 21/07/2018 <https://thewire.in/security/foip-debate-two-sided-strategy-of-engagement-with-china-is-indispensable>
- USAID “Enhancing Development and Growth through Energy” (Feb 6, 2020) <https://www.usaid.gov/energy/asia-edge>(accessed April 5, 2020)
- U.S. State Department. *A free and open indo-pacific: Advancing a Shared Vision* . November 3 2019 Washington D.C:<https://www.state.gov/a-free-and-open-indo-pacific-advancing-a-shared-vision/>
- U.S. Department of State. (2018/07/30). *state.gov*. <https://www.state.gov/r/prs/ps/2018/07/284829.htm>
- Vivek Mishra “India and the Rise of the Indo-Pacific” (2013/09/30). <https://thediplomat.com/2013/09/india-and-the-rise-of-the-indo-pacific/>
- White House “*National Security Strategy of the United States of America*” Washington D.C: The U.S. (December 2017).

Монгол хэлээр:

А.Санчир “АНУ-ын 350 сая ам.долларын тусламжаар ямар ажлууд хийх вэ” (2018 оны Sep 19). *eagle.mn*. <http://eagle.mn/r/50010>

“АНУ-ын Конгрессын Төлөөлөгчдийн танхимд хэлэлцүүлэхээр өргөн барьсан Гуравдагч хөршийн худалдааны хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн дэмжиж байна” (2018 July 30). <https://president.mn/4908/>

Завиер Форнерис «Монгол Улс: хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлийн зураглал» Монгол Банк. УБ. 2019.3.12 https://www.mongolbank.mn/documents/press.../20191022_02e.pdf

Ерөнхий сайд У.Хүрэлсүх АНУ-ын Мянганы сорилтын корпорацид зочлов. Монгол Улсын Гадаад харилцааны яам. (2018/09/22). <http://www.mfa.gov.mn/?p=47869> Accessed May 1, 2020.

Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс дараах тунхаглалыг гаргаж байна. <https://president.mn/10307/> Retrieved May 4, 2020

Монгол Улсын Гаалийн Ерөнхий газар . (2018). Гадаад худалдаа 2017 онд. Улаанбаатар хот: Монгол Улсын Гаалийн Ерөнхий газар

Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын эдийн засгийн өргөтгөсөн түншлэлийн тухай замын зураглал. (2018/09/20). <http://www.mfa.gov.mn/?p=47821>

У.Хүрэлсүх, М.Пэнс нар Монгол, Америкийн харилцаа шат ахиж, өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн түвшинд хүрснийг нотлов. (2018/09/20), <http://www.mfa.gov.mn/?p=47783>

The U.S. policy towards Indo-Pacific region and Mongolia-U.S. strategic partnership

Zolboo Dashnyam*

*Ph.D, Associate Professor
Institute of International Affairs, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia
E-mail: zolbood@mas.ac.mn*

Byambakhand Luguusharav

*Institute of International Affairs, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia
E-mail: byambakhand_l@mas.ac.mn*

Abstract: *Mongolia's security primarily depends on how the country develops respective bilateral relations with its neighbors and great powers including the United States. In this sense, it is important to examine U.S. foreign policy, in particular, its Asia policy as well as interests pursued by Washington while promoting bilateral relations with Mongolia, as the nexus between those parties should be considered in foreign policymaking of Mongolia. On the other hand, relations with Mongolia has been a part of U.S. policy towards the Asia-Pacific region. However, under the leadership of President Trump, the U.S. administration re-defined its policy towards the region by replacing Asia-Pacific with the label of Indo-Pacific. Only two years later since Mongolia and the United States marked the 30th anniversary of the establishment of diplomatic relations, the two countries elevated their ties to a strategic partnership in 2019. In this article, the authors seek to explain what is the Indo-Pacific partnership and express their views.*

Keywords: *USA, Indo-Pacific, Mongolia, Third neighbors policy, Strategic partnership*

<i>The day of submission:</i>	2020.5.18
<i>Completion of review:</i>	2020.6.18
<i>Final decision for acceptance:</i>	2020.6.20